



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2021-2024/

ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН:

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

2021 оны 05 дугаар сарын 24 ны өдөр

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРАЛ

Б.ЭНХТӨР

2021 оны 05 дугаар сарын 19 ны өдөр





ГОВЬСҮМБЭР АЙМАГ НИЙТИЙН НОМЫН САН

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баримт бичгийн үйлчлэх хугацаа: 2021 -2024 он

2021 он

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Стратеги төлөвлөгөө боловсруулах үндэслэл:

Тус байгууллага нь 2021-2025 оныхугацаанд 2012 онд Монгол Улсын Их хурлаас баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, Монгол Улсын “Соёлын тухай хууль”, “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Номын сангийн тухай хууль”, “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын баримт бичиг, аймгийн “2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон бусад хууль эрх зүйн баримт бичгүүд, өнөөгийн нийгмийн чиг хандлага, өөрчлөлт зэргийг үндэслэн үндэс язгээр, төрт ёс, өв соёлоо эрхэмлэж дээдлэн, үндэсний нэгдмэл үнэт зүйлсээ эрхэмлэн Нийтийн Номын сангийн хөгжлийг тодорхойлох стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Тус Нийтийн Номын Сангийн хөгжлийн чиг хандлага, номын сан, ном зүйн мэдээллийг автоматжуулах, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, цахим мэдээллийн санг бий болгох, Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах, судар болон хуучин ном, гар бичмэлийг сурвалжлан олох, нөхөн бүрдүүлэх, олон нийтэд сурталчилах, хадгалах, хамгаалах, хэвийн нөхцөлийг хангаж ажиллахад хэрэгжүүлэх гол нөхцөл болж байна.

Энэхүү төлөвлөгөө нь 2021-2025 оныг дуустал аймгийн Нийтийн номын санг цаашид хөгжүүлэхэд аймаг, орон нутаг, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хүн амд монголын түүх, боржигин өв соёл, мэдлэг мэдээлэлийн хэрэгцээг хангах үндсэн баримт бичиг болох юм.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилго нь номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөх стандартад нийцсэн, орчин нөхцөлд зохих үйлчилгээг уншигчид үзүүлэх, уншлагын үйлчилгээг зохих журмын дагуу хүргэх, сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах, сан хөмрөгийн эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах, соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, мэдээлэл технологийн шинэчлэл болон өөрийн хөгжих чадварыг хангахуйц тогтвортой үйл ажиллагааг бий болгон хөгжүүлэхэд оршино.

1.2. Стратеги төлөвлөгөө боловсруулсан арга зүй

Стратеги боловсруулахдаа стратегийн төлөвлөлтийн зарчим, арга хэрэгсэл, технологид үндэслэн дор дурдсан дарааллыг баримталсан болно.

➤ Төлөвлөлтийн баг бүрдүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, төлөвлөгөөг хийх дарааллыг гаргах:

➤ Номын сангийн өнөөгийн төлөвийг тодорхойлох :

➤ Номын сангийн орчны үнэлгээ хийх:

➤ Номын сангийн хөгжлийн 2021-2025 оны төлвийг тодорхойлж, зорилгоо тогтоох:

➤ Зорилгод хүрэх арга зам, стратегийг боловсруулж тодорхойлох, томъёолох:

➤ Зорилго, зорилтуудыг тоон болон чанарын үзүүлэлтээр илэрхийлэх:

➤ Хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах:

➤ Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тохиолдож болзошгүй эрсдэл, зардлын тооцоо гаргах:

1.3. Стратеги төлөвлөгөөг боловсруулсан хэрэгцээ, шаардлага, анхаарах асуудал

Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын сан нь 2004 онд Говьсүмбэр аймгийн Боловсрол Соёлын Газрын харъяанд аймгийн Музей, номын сан нэртэйгээр Номын санч, музейн тайлбарлагч орон тоотой байгуулагдан улмаар аймгийн Засаг даргын 2005 оны А/125 дугаар захирамжаар бие даасан байгууллага болон өргөжин, аймгийн иргэд уншигчдад ном, хэвлэл, мэдээллээр үйлчлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд туслах зорилгоор 7-н чиглэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.


Мэдээллийн техник, технологийн хөгжлийн нөлөөгөөр мэдээллийн зууны номын сангийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, улс орны нийгэм, соёлын салбарт эзлэх байр суурь, ач холбогдол өсөн нэмэгдэж, бие хүнийг бүтээлчээр хөгжүүлэх мэдээллийн нээлттэй үүрэг гүйцэтгэх болсон.

Манай Нийтийн номын сан нь 5671 төрлийн 9909 ширхэг ном хэвлэл болон бусад материал бүхий мэдээллийн нөөц, цаасан болон электрон каталогоор иргэд, уншигчдад үйлчилж байна.


Байгуулагдснаас хойших хугацаанд өөрийн байгууллагын батлагдсан төсвийн санхүүжилтээр фондоо баяжуулж, бэлэг хандив, орон нутаг, төсөл хөтөлбөрт оролцон үйлчилгээг өөрчлөх, өргөтгөх интернэт үйлчилгээ зэрэг

шинэчлэлтүүдийг нэвтрүүлснээр номын сангийн суурин үйлчилгээнд хамрагсдын тоо нэмэгдэж байна. Үүний зэргцээ аймгийн төвөөс алслагдсан сум, багийн хүн амд нүүдэл, зөөврийн үйлчилгээг гэр, сургууль, ажлын байранд нь хүргэж байна.

Уншигчдийн гарфик үзүүлэлтийг сүүлийн 2 жилээр харьцуулбал:



Уншигчдын харьцуулалт:



Дээрхи гарфикийг харвал давхардсан тоогоор 2019 онд нийт 18943 үйлчлүүлэгч, 2020 онд 22134 үйлчлүүлэгч номын сангаар үйлчлүүлсэн бөгөөд 2020 онд 3191 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна.

Говьсүмбэраймгийнхунамынтоо 2020 онытооллогоор 17928 болсонбайна. Хунамньнасныхувьдзалуухэвээрээбайгаабөгөөд 0-14 насныхүүхэд 6072 буюу 33.9 хувь, 15-64 насныхунам 11203 буюу 62.5 хувь, 65, түүнээсдээшнасныхунам 653 буюу 3.6 хувийгтустусэзэлжбайна.

Номын сангаар давхардсан тоогоор үйлчлүүлэгчдийн жилийн дундаж үзүүлэлтийг хүн амтай харьцуулахад 80-% д хүрч байгаа нь сайшаалтай, хангалттай үзүүлэлт юм.

Гэвч уншигчдийг дотор нь үйлчилгээ авсан төрлөөр харьцуулахад цахим үйлчилгээ нэмэгдэж, танхимын үйлчилгээ буурсан үзүүлэлт гарч байна.Танхимын үзүүлэлт буурсан шалтгаан нь “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор 2020 оны 03-р сараас эхлэн уншлага үйлчилгээг цахимаар явуулсан болно.

Үүнээс хархад номын сангаар үйлчлүүлэх ,унших хандлага нь ихэссэн байгаа сайн талтай боловч нөгөө талаас эдгээрт нөлөөлөх олон хүчин зүйлүүд байна.

Тухайлбал:Өнөөдөр цаасан соёл иргэншлээс цахим соёл иргэншил рүү, өөрөөр хэлбэл хүмүүс унших тогтолцооноос үзэх, харах тогтолцооруу шилжсэнтэй уялдан иргэдийн чөлөөт цагийн бүтэц өөрчлөгдсөн, интернэт болон бусад мэдээллийн хэрэгслэл, эх сурвалжаас мэдээлэл авах боломж бий болсон гэх мэт.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь өнөөгийн нөхцөл байдлыг өөрчлөх, нийгмийн сэтгэл зүйд номын сангийн үйлчилгээний байр суурийг бэхжүүлэх зорилгоор мэдээллээр хангах, номын сангийн фондыг сурталчлах, сургалт, судалгааны эргэлт, ашиглалтыг нэмэгдүүлэхэд томоохон хувь нэмрийг оруулах юм.

Уншлагыг дэлхий дахинаа мэдээллийн зуунд амьдрах гол түлхүүр төдийгүй үндэстний хөгжлийн тулгуур багана гэж үзэх болсон байна.

Иймээс аймгийн Нийтийн номын сангуудын нийгэмд гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг шинээр тодорхойлон шинжлэх ухааны үндэслэлтэй олон улсын нийтлэг аргачлал, арга зүйг үйлчилгээнд нэвтрүүлэх нийгмийн хэрэгцээ, шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

Стратеги төлөвлөгөө боловсруулах баг нь байгууллагын үйл ажиллагааны тулгамдсан асуудал, давуу, сул талыг тодорхойлохын тулд номын сангийн үндсэн тулгуур баримт бичгүүд, тайлан, төлөвлөгөө, номын сангийн ажилтан албан хаагчдын дунд явуулсан хэлэлцүүлэгийн дүн болон хэрэглэгчдийн санал асуулгын үнэлгээг тус тус үндэслэсэн болно.

Үйлчлүүлэгчдээс санал асуулга, хэрэглэгчдийн үнэлгээг бичгээр болон онлайн хэлбэрээр авсан.

Өнөөдрийн байдлаар манай Нийтийн номын санд нэн түрүүнд дараах тулгамдсан асуудал байна. Үүнд:

- Номын сан мэдээлийн байгууллагад мөрдөх стандартын F хавсралт буюу номын сангийн үйлчилгээний хүрээ, мэргэжлийн албан тушаал, орон тооны жишиг дээр үндэслэн бүтцийн уянхатан тогтолцоо бий болгох
- Номын сангийн үйл ажиллагаа явуулж буй байрыг стандартын дагуу засварлах, шинэчлэх
- Мэдээллийн техник технологид суурилуулсан, Боржигин өв соёл, түүхийг хадгалсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нийтэд танигдсан бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон хэрэглэгчдийн хэрэглээ болгон төлөвшүүлэх

ХОЁР: МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс батлагдан мөрдөгдөж байгаа Номын сангийн тухай хууль, бусад нийтлэг болон тухайн салбарын хүрээнд мөрдөгдөж байгаа удиртгал болгон "Мандатын шинжилгээ"-г Ерөнхий 1, үндсэн 3, дэд 17, хамтран хэрэгжүүлэх 24 чиг үүргийг тодорхойлж, дараах хүснэгтээр харуулав.

Мандатын шинжилгээг хийхэд дараах хуулийг үндэслэл болгон авч үзлээ. Үүнд: **Хүснэгт 1.**

Хуулийн жагсаалт

Нийтлэг мөрдөгддөг хууль	Чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа хууль
Төрийн албаны тухай хууль	Номын сангийн тухай хууль
Хөдөлмөрийн тухай хууль	Соёлын тухай хуулт
Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Төсвийн тухай хууль	
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	
Захиргааны ерөнхий хууль	
Зөрчлийн тухай хууль	
Гамшгаас хамгаалах тухай хууль	
Монгол хэлний тухай хууль	

Мандатын шинжилгээ, чиг үүрэг

Хүснэгт 2

Чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		12
Үүнээс	Номын сангийн чиг үүргийн хүрээнд мөрдөгддөг хуулийн тоо	3
	Нийтлэг мөрдөгддөг хуулийн тоо	9
Ерөнхий чиг үүрэг-1: Номын сангийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, "Боржигин өв соёл"-ыг түгээн дэлгэрүүлэх, утга соёлын өвийн бүртгэл, судалгааг хийх, номын сангийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах:		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
Үндсэн чиг үүрэг-1 Иргэдэд ном хэвлэл мэдээллээр үйлчлэх, боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлэх:	- Цахим болон зөөврийн, нүүдлийн, гэрээр ном олгох үйлчилгээг нэмэгдүүлэх - Сан хөмрөгийн баяжилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах - Номын сангийн үйл ажиллагаа, ном, хэвлэлийг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах - Иргэдэд Боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах - Ховор ном сударыг бүртгэж, фонд үүсгэх - Номын үзэсгэлэн гаргах, - Номын сангийн үйлчилгээг цахимжуулах	- Стандартад нийцсэн номын сангийн үйлчилгээг уншигчид үзүүлэх, уншлагын үйлчилгээг зохих журмын дагуу хүргэх - Иргэд, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номоор дамжуулан эх хэл, түүх соёл, мэдлэг боловсрол, хүмүүжил олгох ажлыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллагыг түшиглэн хөгжүүлэх - Контент нэвтрүүлэгээр иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх - Фондын ном хэвлэлийг бэлэг хандив, улсын төсвийн хөрөнгөөр нэмэгдүүлэх - Орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, орон нутгийн иргэнийг номын сангийн үйлчилгээнд өргөн хамруулах арга хэмжээг зохион байгуулах - Эрдэм шинжилгээний номын сан судалгаа шинжилгээ, мэдээллийн түшиц газар байж, судалгаа шинжилгээний үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий үйлчилгээ үзүүлэх - Иргэдийн гар дээр хадгалагдаж буй ховор ном судрын судалгааг хийж, бүртгэн, фондыг баяжуулах - Цаг үеийн ач холбогдол бүхий номын үзэсгэлэнг гаргаж олон нийтэд хүргэх - Боржигин өв соёл, утга соёлыг хамгаалах, судалж, сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулах, утга соёлын өвийг өвлөн тээгч, билиг авъяастаныг судлан тодорхойлж, уран бүтээлээ туурвих, хойч үед уламжлуулахад туслан дэмжлэг үзүүлэх - Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742:2019 стандартын шаардлагад нийцсэн үйлчилгээний төрөлжсэн зориулалтын танхимуудаар үйлчлэх

Үндсэн чиг үүрэг-2: Номын сангийн хөгжлийн бодлого, хууль эрх зүй, үйл ажиллагааны тайлагнал, хяналт, шинжилгээ үнэлгээ	• Аймгийн болон соёлын байгууллагын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ үнэлгээг хийх, тайлагнах • Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, холбогдох сургалт, сурталчилгааг хийх • Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах • Байгууллагын стратеги төлөвлөгөө, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах	• Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт • Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт • Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт • Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт • Байгууллагын даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт • Соёлын салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилт • Салбарын эрх зүйн холбогдох хууль тогтоомжийн биелэлт
Үндсэн чиг үүрэг-3 Номын сангийн үйл ажиллагааг хөгжүүлэн дэмжих, хүний нөөц, төсөв санхүү, технологийг дээшлүүлэх	• Хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх • Мэргэжил дээшлүүлэх урт богино хугацааны сургалтанд албан хаагчдыг хамруулж мэргэжил, мэргэшлийг ахиулах • Сумдын болон байгууллагуудын номын сангийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх • Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах • Байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх • Төсөв санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах	• Үндэсний Номын сан болон бусад аймгийн Номын сангийн үйл ажиллагаанаас туршлага судлах, шинэ бүтээлч ажлыг санаачлан нэвтрүүлэх • Мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, ахисан түвшний сургалтанд тогтмол хамруулах • Сумдын болон ЕБС-иудын номын санг хөгжүүлэх, үйл ажиллагааг дээшлүүлэхд хамтран ажиллах, мэргэжилтэнгүүдэд үе шаттай сургалт зохион байгуулах, хамтран ажиллах • Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, шилэн данс болон вэб сайтын үйл ажиллагааг сайжруулах • Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл • Албан хаагчдын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт • Төсвийн ил тод байдал, хууль журмын хэрэгжилт

ГУРАВ: АЛСЫН ХАРАА

Номын санг сургалт, эрдэм шинжилгээ, мэдээллийн төв болгон хөгжүүлж, хүн амд үзүүлэх номын сангийн үйлчилгээний чанар хүрээ, хүртээмжийг сайжруулахад оршино.

ДӨРӨВ: ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгч бүрт мэдээлэл хүртэх боломжийг олгох, мэдээллийн эрин үед хэрэглэгчдэд интернэт дэх, дижитал эх сурьалжуудад тулгуурласан электрон мэдээллээр үйлчлэх.

Эрхэм зорилгыг биелүүлэхэд баримтлах үндсэн зарчим:

- Мэргэжлийн байгууллагын жишиг хэмжээнд нийцүүлэн ажиллах
- Номын сангийн үйлчилгээг хүн бүрт хүртээмжтэй хүргэх
- Хөдөөгийн хүн амд хүргэх мэдээлэл, номын сангийн үйлчилгээг чухалчлах
- Олон нийтийн хамтын ажиллагааг эрхэмлэх

ТАВ: ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Номын Сангийн дотоод болон гадаад орчны шинжилгээний үр

дүнг нэгтгэх SWOT хүснэгт

Хүснэгт-3

Дотоод орчин	
<u>Давуу тал:</u> - Үйл ажиллагаа тогтмолжсон - Ажиллах, туршлага дадал бүхий мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан - Номын сангийн LIB-4 цогц программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үйлчилгээг автоматжуулан, электрон каталогийг бий болгосон - Монголын болон Дэлхийн шилдэг зохиол бүтээлээс бүрдсэн өргөн сонголт бүхий 9000 гаруй номын фондтой - Төрийн болон төрийн бус байгууллагууд, зохиолч, уран бүтээлчидтэй хамтран ажилладаг	<u>Сул тал:</u> - Номын сангийн зориулалтын стандартын байргүй - Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742:2019 стандартын шаардлагад нийцсэн үйлчилгээний төрөлжсэн зориулалтын танхимууд байхгүй - Сан хөмрөгийн баяжилт хийхэд төсөв бага - Ном хэвлэлийг бүрэн болон хэсэгчилсэн цахим уншлагын үйлчилгээнд оруулах боломжгүй
Гадаад орчин	
<u>Боломж:</u> -Мэдээллийн технологид суурилсан Номын сангийн цахим үйлчилгээг өргөжүүлэх:	<u>Эрсдэл:</u> - Байгууллагын тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн боловсон хүчний

- Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх: - Улсын болон бусад аймгийн номын сангийн хамтын ажиллагааны уламжлалыг нэвтрүүлэх - Иргэдийн гар дээрхи ганц хувь бүтээл, гар бичмэл, ховор ном судрыг сурьалжлан олох	- шилжилт хөдөлгөөн /шилжих, тэтгэвэрт гарах гэх мэт/ - Хүний нөөцийн хөгжил, бүтээлч санаачлага сулрах - Давтагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл, нийгэм, эдийн засаг, улс төрөөс шатгаалан удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлт - Техник технологийн үсрэнгүй хөгжлийн хоцрогдол - Байгалийн гамшиг, сүйрэл, хүний гоц халдварт өвчний хорио, цээрийн дэглэмийн үйл ажиллагаа
---	---

ЗУРГАА: СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Номын сангийн хөгжлийн төлөвлөгөөний эрхэм зорилгыг биелүүлэх үйл ажиллагааны хүрээнд үйлчилгээний хэтийн чиг хандлага дээр тулгуурласан дараах багц зорилтуудыг тодорхойлж байна.

Зорилтууд:

Зорилт 1. Уншлага үйлчилгээний ажлыг зохион байгуулах

Аймгийн иргэд, уншигчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн ном хэвлэл, мэдээ мэдээллийг хүргэх номын сангийн үйл ажиллагаа ньнийгмийн хөгжлийг даган жилээс жилд хөгжиж, өөрчлөгдөж байна.

Аймаг, орон нутгийн хөгжилд иргэд нь “хир зэрэг уншиж, өөрийгөө яаж өөрчлөн амьдралын хэрэгцээгээ хангаж байна” гэдгээс ихээхэн шалтгаалах болсон.

Өөрөөр хэлбэл улс орны хөгжлийн эхлэл нь номын сан болсон байна.

Уншдаг үндэстэн хөгждөг гэсэн нийгмийн хөгжлийн томъёолол байдаг. Иймээс бид номын сангийн уламжлалт үйлчилгээнээсээ илүү нийгмийн сүлжээ ашиглан өөрсдийн мэдээллийн нөөцийг аль болох олон хэрэглэгчдэд сурталчилан, таниулан хүргэх шаардлагатай байна.

Номын сан-мэдээллийн нөөц бүрдүүлэлтийг уламжлалт болон цахим хэрэглээтэй хослуулах замаар мэдлэг мэдээллийг олон нийтэд хүргэх гүүр нь номын сан юм.

Энэ зорилтын хүрээнд:

- Нийтийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэр бүлийн уншлагын танхим
- Хөгжлийн болон харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх танхим
- Гэрээр ном олгох танхим зэрэг төрөлжсөн танхимуултай болох

Зорилт 2. Иргэд, уншигчдын хэрэгцээт шаардлагатай ном хэвлэл, мэдээллийн материалаар сан хөмрөгийг баяжуулах

Орон нутгийн хүн амын уншлагын эрэлт хэрэгцээнд нийцсэн ном хэвлэлийн сан хөмрөгийг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлж, номын эргэлтийг сайжруулах, нөхөн бүрдүүлснээр уншигчдын эрэлт хэрэгцээг хангана.

Энэ зорилтын хүрээнд:

- Сан хөмрөгийн цаасан болон цахим каталоги, картын санг бүрдүүлэх, уншигчдад ашиглуулах ажлыг зохион байгуулах
- Хэвлэмэл болон хэвлэлмэл бус номоор сан хөмрөгөө бүрдүүлэх
- Стандартын дагуу ном хэвлэлийг хадгалах, хамгаалах, хэвийн нөхцөлийг бүрдүүлэх сайжруулах, хяналт тавих

Зорилт 3. Ном хэвлэл болон соёл олон нийтийн ажил, уралдаан тэмцээнийг сурталчилах

Уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ном хэвлэлийг орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан сурталчлах, зохион байгуулж буй соёл олон нийтийн арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайтуудаар сурталчилан таниулж иргэдэд хүргэнэ.

Энэ зорилтын хүрээнд:

- Нийтийн Номын Сангийн цахим пэйж хуудсаар үйл ажиллагааг сурталчилах
- Орон нутгийн телевиз, сонин сэтгүүлэр сурталчилах
- Ном хэвлэлийг шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчилах

Зорилт 4. Хүний нөөцийн хөгжил-байгууллагын амжилтын үндэс

Одоогийн байдлаар тус номын сан нь хүний нөөцийн судалгаагаар 10 ажилтантай, үүнээс Захирал-1, Арга зүйч-сүлжээний инженер-1, ном зүйч-1, номын санч-мэдээлийн ажилтан-2, сан хөмрөгч-хүний нөөц-1, бусад ажилтан-4, мэргэжлийн зэргийг судлахад дээд боловсролтой буюу баклавар 80%, бүрэн дунд 20%, номын сангийн мэргэжлийн ажилтан 4 буюу 50-ийг эзэлж байна.

Дээрхи тоо баримтаас үзэхэд эрдмийн зэрэг, цолтой номын санчдын тоог нэмэгдүүлэх, номын санчдыг эрдэм шинжилгээ судалгааны ажилд татан оролцуулах, мэргэжлийг нь номын сангийн сургалтын болон судалгааны байгууллагуудтай хамтран дээшлүүлэх шаардлагатай байна.

Номын сангийн хөгжлийн дэлхийн чиг хандлага, нийгмийн өөрчлөлт, дижитал үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдан номын санчдын хөдөлмөр, үүрэг хариуцлага үндсээрээ өөрчлөгдөн шинэчлэгдэж байна.

Мөн нийгмийн хөгжил хувьсал, мэдээллийн технологийн шинэчлэлтэй уялдсан номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээ үндсээрээ өөрчлөгдөж

байгаа учраас номын санчдыг хөгжүүлэх нь хамгийн чухал зорилтын нэгж болж байна.

Ийм учраас байгууллагыг хөгжүүлэх 4 жилийн “стратегийн төлөвлөгөө”-ний хүрээнд “Байгууллагын хүний нөөцийн менежмент”-ийг боловсронгуй болгон хөгжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

Хүний нөөцийн хөгжлийн гол зорилго нь ажилтан бүрийн хувийн мэдлэг чадварыг бүрэн нээж хөгжүүлэн оновчтой ашиглах явдал юм.

Ажилтан бүрийн мэдлэг чадвараас байгууллагын хөгжил дэвшил, нийгэмд эзлэх байр суурь шууд хамааралтай.

Зорилт 5. Бодлогын бичиг баримтын хүрээнд үйл ажиллагааг төлөвлөх

Аймгийн хүн амыг номын сангийн үйлчилгээнд хамруулах, нийгэм дэх номын сангийн ач холбогдол, үнэлэмжийг нэмэгдүүлэх шаардлагын улмаас бодлогын төлөвлөлтийг зөв зохион байгуулах зайлшгүй шаардлагатай.

Энэ хүрээнд:

1. Төрөөс соёлын талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх
2. Номын сангийн төлөвлөлтийг бодлогын түвшинд зохион байгуулах

Зорилт 6: Гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх:

Номын сангийн хувьд улсын томоохон номын сангуудтай холбоотой ажиллаж, албан ёсны хамтын ажиллагаа өргөжүүлэх нь тасралтгүй хөгжил, цаашдын үйл ажиллагааны төлөвлөлт зэрэгт гол холбоо болдог.

Энэ хүрээнд:

- Улаанбаатар болон бусад аймгийн нийтийн номын сангуудтай хамтран ажиллах, мэдээллийн нөөц болон мэргэжилтэн солилцох
 - Номын сангийн найз нөхдийн холбоо үүсгэх
 - Бусад судалгаа, сургалтын болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах
- Жишээлбэл: музей, архив, бизнесийн байгууллага гэх мэт.

**ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ**

Нийтийн Номын Сангийн 2020-2024 онд хэрэгжүүлэх стратеги зорилт, арга хэмжээ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүрэг-1. Стандартад нийцсэн номын сангийн үйлчилгээг уншигчид үзүүлэх, уншлагы үйлчилгээг зохих журмын дагуу хүргэх; ҮЧҮ: Иргэдэд ном хэвлэл мэдээллээр үйлчлэх:					
Зорилт 1: Уншлага үйлчилгээний ажлыг зохион байгуулах	<u>Арга хэмжээ-1:</u> Уншлагын танимаар үйлчлэх	Нийт уншигч 20120	Нийт уншигч 15765	Нийт уншигч 32000	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-2:</u> Гэрээр ном олгох үйлчилгээ	Нийт уншигч 630	Нийт уншигч 583	Нийт уншигч 800	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-3:</u> Зөөврийн номын үйлчилгээ	Нийт уншигч 516	Нийт уншигч 500	Нийт уншигч 720	Байгууллагын төсөв
Ерөнхий чиг үүрэг-2. Номын сангийн сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах, эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах; ҮЧҮ: Сан хөмрөгийн баяжилт, хадгалалт хамгаалалт					
Зорилт 2. Иргэд, уншигчдын хэрэгцээт шаардлагатай ном хэвлэл, мэдээллийн	<u>Арга хэмжээ-1</u> Сан хөмрөгийг төсвийн хөрөнгөөр баяжуулах	Ном хэвлэлийн тоо-450	Ном, хэвлэлийн тоо-339	Ном хэвлэлийн тоо-1000	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-2</u>	Ном хэвлэлийн	Ном хэвлэлийн	Ном хэвлэлийн	Бэлэг,

материалаар сан хөмрөгийг баяжуулах	Сан хөмрөгийг бэлэг, хандиваар баяжуулах	тоо-440	тоо-237	тоо-1110	хандиваар
	<u>Арга хэмжээ-3</u> Сан хөмрөгийг соёл урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хөрөнгөөр баяжуулах	Ном хэвлэлийн тоо-250	Ном хэвлэлийн тоо-248	Ном хэвлэлийн тоо-320	Хөтөлбөрийн хөрөнгө
	<u>Арга хэмжээ-4</u> Сан хөмрөгийн тооллогыг жилд 2 удаа хийх	Жилд 2 удаа	Жилд 2 удаа	Жилд 2 удаа	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-5</u> Урагдаж, гэмтсэн ном, хэвлэлийг сэлбэн засах	Сэлбэн засах ном 270	Сэлбэн засах ном 260	Сэлбэн засах ном 450	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-6</u> Ном хэвлэлийг стандартын дагуу ариутгах, мэргэч амьтан, хортон шавьжнаас хамгаалах	Ариутгал, цэвэрлэгээг жилд 2 удаа Хортон шавьжнаас хамгаалах ажлыг жилд 1 удаа	Ариутгал, цэвэрлэгээг жилд 2 удаа Хортон шавьжнаас хамгаалах ажлыг жилд 1 удаа	Ариутгал, цэвэрлэгээг жилд 2 удаа Хортон шавьжнаас хамгаалах ажлыг жилд 1 удаа	Байгууллагын төсөв
Ерөнхий чиг үүрэг-3: Номын сангийн үйл ажиллагааг олоннийтэдсурталчлах: ҮЧҮ: Номын сангийн үйл ажиллагаа, ном, хэвлэлийг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах					
<u>Зорилт-3</u> Ном хэвлэл болон соёл олон нийтийн ажил, уралдаан тэмцээнийг сурталчилах	<u>Арга хэмжээ-1</u> Боржигин түмний өвсоёлыг түгээн дэлгэрүүлж, залуу үед өвлүүлэх сурталчилан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулах ажлын тоо-2	-	Зохион байгуулах ажлын тоо-3	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-2</u> Үндэсний бичиг үсгийн баярын	Арга хэмжээнд хамрагдсан	Арга хэмжээнд хамрагдсан	Арга хэмжээнд хамрагдсан	Байгууллагын төсөв

	арга хэмжээ зохион байгуулах	иргэдийн тоо-300	иргэдийн тоо-100	иргэдийн тоо-500	
	<u>Арга хэмжээ-3</u> Хөгжлийн бэрхшээлтэй, харааны болон зорилтот бүлгийн хүүхэд, иргэдийн дунд сарын аян зохион байгуулах	Зохион байгуулах ажлын тоо-4 хамрагдсан иргэдийн тоо-260	Зохион байгуулах ажлын тоо-3 хамрагдсан иргэдийн тоо-80	Зохион байгуулах ажлын тоо-6 хамрагдсан иргэдийн тоо-350	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-3</u> Уншлагын аян зохион байгуулах	Зохион байгуулах ажлын тоо-3 хамрагдсан иргэдийн тоо-12500	Зохион байгуулах ажлын тоо-3 хамрагдсан иргэдийн тоо-4000	Зохион байгуулах ажлын тоо-5 хамрагдсан иргэдийн тоо-18000	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-4</u> Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, ном хэвлэлийг сурталчилах	Шинэ номын үзэсгэлэнгийн тоо-6 Сэдэвчилсэн номын үзэсгэлэнгийн тоо-36 Үзэсгэлэнд хамрагдсан иргэдийн 2100	Шинэ номын үзэсгэлэнгийн тоо-5 Сэдэвчилсэн номын үзэсгэлэнгийн тоо-12 Үзэсгэлэнд хамрагдсан иргэдийн тоо 700	Шинэ номын үзэсгэлэнгийн тоо-10 Сэдэвчилсэн номын үзэсгэлэнгийн тоо-45 Үзэсгэлэнд хамрагдсан иргэдийн тоо 2700	Байгууллагын төсөв
Ерөнхий чиг үүрэг-4:Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах: ҮЧҮ- Мэргэжлийн ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх нийгмийн асуудлыг шийдвэрлэх					
<u>Зорилт 4.</u> Хүний нөөцийн хөгжил-байгууллагын	<u>Арга хэмжээ-1:</u> Албан хаагчдын Монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлэх	Монгол бичгийн дунд шатны сургалтад	Монгол бичгийн анхан шатны сургалтад хамрагдсан албан	Монгол бичгийн анхан ахисан түвшний сургалтад	Байгууллагын төсөв

амжилтын үндэс		хамрагдсан албан хаагчийн тоо-10	хаагчийн тоо-9	хамрагдсан албан хаагчийн тоо-12	
	<u>Арга хэмжээ-2:</u> Мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт-5 Хамрагдсан алба хаагч /давхардсан тоогоор/ -60	Зохион байгуулсан сургалт-4 Хамрагдсан алба хаагч/давхардсан тоогоор/ - 44	Зохион байгуулсан сургалт-8 Хамрагдсан алба хаагч/давхардсан тоогоор/ -112	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-3:</u> Орон нутаг болон Мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалтад албан хаагчдыг хамруулах	Зохион байгуулсан сургалт-23 Хамрагдсан алба хаагч /давхардсан тоогоор/ -160	Зохион байгуулсан сургалт-18 Хамрагдсан алба хаагч/давхардсан тоогоор/ - 60	Зохион байгуулсан сургалт-35 Хамрагдсан алба хаагч/давхардсан тоогоор/ -250	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-4:</u> Албан хаагчдыг салбарын болон аймаг, Төрийн дээд одон медальд тодорхойлж шагнаж урамшуулах	Тодорхойлсон албан хаагчийн тоо-2 Шагналын тоо- 2	Тодорхойлсон албан хаагчийн тоо-2 Шагналын тоо-1	Тодорхойлсон албан хаагчийн тоо-5 Шагналын тоо-5	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-5:</u> Албан хаагчдад ур чадвар, тусламж, дэмжлэг, тэтгэмж үзүүлэх	Албан хаагчдын тоо-10	Албан хаагчдын тоо-9	Албан хаагчдын тоо-10	Байгууллагын төсөв

	<u>Арга хэмжээ-6:</u> Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилд 1 удаа	-	Жилд 2 удаа	Байгууллагын төсөв
Е Ерөнхий чиг үүрэг-5: Номын сангийн бодлого төлөвлөлтийг сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах					
ҮЧҮ: Үйл ажиллагааны бодлогын баримт бичгийг төлөвлөх, сумдын болон сургуулийн номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах					
<u>Зорилт 5.</u> Бодлогын бичиг баримтын хүрээнд үйл ажиллагааг төлөвлөх	<u>Арга хэмжээ-1:</u> Хүний нөөцийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-2</u> Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-3</u> Албан хаагчдыг чадавхижуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-4</u> Байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил бүр төлөвлөх	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Гүйцэтгэлийн хувиар 80-90	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-5</u> Сумдын болон ерөнхий боловсролын сургуулийн	Мэргэжил арга зүйгээр хангасан	Мэргэжил арга зүйгээр хангасан ажлын тоо-4	Мэргэжил арга зүйгээр хангасан ажлын тоо-8	Байгууллагын төсөв

	номын сангуудад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах	ажлын тоо-2			
Ерөнхий чиг үүрэг-6: Гадаад , дотоодын номын сан, ном хэвлэлийн*байгууллагуудтай хамтран ажиллах					
ҮЧҮ: Гадаадын болон дотоодын номын сангууд, Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллах					
Зорилт 6: Гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх:	<u>Арга хэмжээ-1</u> Улаанбаатар хотын болон аймгийн номын сангуудаас туршлага судлах, хамтран ажиллах	2 аймгийн Нийтийн Номын сантай хамтран ажиллах гэрээ байгуулах	2 аймгийн Нийтийн Номын сангийн туршлага судалсан.	5 аймгийн Нийтийн Номын сантай хамтран ажиллах гэрээ байгуулах	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-2</u> Хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах	2 байгууллагатай хамтран ажиллах гэрээ хийж ажиллах	2 байгууллагатай хамтран ажиллах гэрээ хийж ажиллах	2 байгууллагатай хамтран ажиллах гэрээ хийж ажиллах	Байгууллагын төсөв
	<u>Арга хэмжээ-3</u> Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	5 байгууллагатай хамтран ажиллах гэрээ хийж ажиллах	4 байгууллагатай хамтран ажиллах гэрээ хийж ажиллах	10 байгууллагатай хамтран ажиллах гэрээ хийж ажиллах	Байгууллагын төсөв
Зорилт 7: Аймаг орон нутаг, байгууллагын хөгжлийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх	<u>Арга хэмжээ-1</u> Аймгийн стратеги төлөвлөгөө 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний Үндсэн чиг үүрэг 2-ын Зорилт-8 ыг хэрэгжүүлэх	“Соёлын урлаг” төгөл байгуулах	-	Соёл урлагийн чиглэлийн төрийн бус байгууллагуудтай хамтран төгөлийг жил бүр өргөжүүлэх	Байгууллагын төсөв